

ЦАХИЛГААН ХОЛБООНЫ СҮЛЖЭЭНД ХОЛБОГДОХ, СҮЛЖЭЭ ХООРОНДЫН ХАРИЛЦАН ХОЛБОЛТЫН ЕРӨНХИЙ ЖУРАМ

Нэг. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1.1. Монгол Улсын нутаг дэвсгэрт харилцаа холбооны нийтийн болон өртөг нэмэгдүүлэх үйлчилгээ эрхлэх зорилгоор цахилгаан холбооны сүлжээнд холбогдох болон сүлжээ хоорондын харилцан холболт зэрэг үйл ажиллагааны үед үүсэн харилцааг энэхүү журам болон энэ журмын дагалдах хавсралт журмуудаар зохицуулна.

1.2. Сүлжээний хэсэгчилсэн түрээс, дэд бүтцийг хувааж ашиглах, түүнчлэн өөрийн барилга байгууламжийн байршлийг ашиглуулах зэрэг бусад харилцааг энэ журмын дагалдах хавсралт журмаар зохицуулна.

1.3. Энэхүү журам болон энэ журмын дагалдах хавсралт журмаар зохицуулагдах үйл ажиллагааны дараах төрлүүд байна. Үүнд:

1.3.1. Сүлжээ хоорондын харилцан холболт */interconnection/* гэдгийг өөрийн сүлжээ байгуулан харилцаа холбооны нийтийн үйлчилгээ эрхлэгчид буюу “А” ангиллын тусгай зөвшөөрөл эзэмшигчид нь өөрийн үйлчилгээг бусад сүлжээний хэрэглэгчдэд хүргэх, өөрийн хэрэглэгчдэд бусдын үйлчилгээг хүртээх зорилгоор сүлжээгээ бусад сүлжээнд холбохыг ойлгоно.

1.3.2. Цахилгаан холбооны сүлжээнд холбогдох */access/* гэдгийг харилцаа холбооны нийтийн үйлчилгээ эрхлэгчид буюу “Б” ангиллын тусгай зөвшөөрөл эзэмшигчид болон өртөг нэмэгдүүлэх үйлчилгээ эрхлэгчид цахилгаан холбооны сүлжээг ашиглан өөрийн хэрэглэгчдэд үйлчилгээгээ хүргэх зорилгоор цахилгаан холбооны сүлжээнд холбогдохыг ойлгоно.

1.3.3. “Хэсэгчилсэн түрээс” */Unbundling/* гэдэг нь харилцаа холбооны нийтийн үйлчилгээ болон өртөг нэмэгдүүлэх үйлчилгээ эрхлэгчид нь цахилгаан холбооны сүлжээнд холбогдох болон сүлжээ хоорондын харилцан холболт хийхтэй холбогдон сүлжээний аль нэг хэсгийг түрээслэх, түрээслүүлэхийг ойлгоно.

1.3.4. “Дэд бүтцийг хувааж ашиглах” */Infrastructure sharing/* гэдэг нь харилцаа холбооны нийтийн үйлчилгээ болон өртөг нэмэгдүүлэх үйлчилгээ эрхлэгчид нь цахилгаан холбооны сүлжээнд холбогдох болон сүлжээ хоорондын харилцан холболт хийхтэй холбогдон сүлжээний тоног төхөөрөмж, байгууламжийг хуваан ашиглахыг ойлгоно.

1.3.5. “Барилга байгууламжийн байршлыг ашиглуулах” /Collocation/ гэдэг нь харилцаа холбооны нийтийн үйлчилгээ болон өртөг нэмэгдүүлэх үйлчилгээ эрхлэх зорилгоор цахилгаан холбооны сүлжээнд холбогдох болон сүлжээ хоорондын харилцан холболт хийхэд сүлжээ эзэмшигч нь өөрийн барилга байгууламж, түүний доторхи байр, байршлийг ашиглуулахыг ойлгоно.

1.4. Монгол Улсын иргэн, хуулийн этгээд, харилцаа холбооны үйлчилгээ эрхлэгч нь цахилгаан холбооны сүлжээнд холбогдох, бусад сүлжээтэй харилцан холболт хийхдээ Харилцаа холбооны тухай, Шударга бус өрсөлдөөнийг хориглох тухай, Радио долгионы тухай хууль, тэдгээрт нийцүүлэн гаргасан дүрэм, журам, харилцаа холбооны ашиглалт үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлага болон энэхүү журмыг мөрдлөгө болгоно.

1.5. Энэхүү журамд Монгол Улсын Харилцаа холбооны тухай хуулинд зааснаас бусад дараах нэр томъёоны тодорхойлолтыг хэрэглэнэ. Үүнд:

1.5.1. “Тал” ба “Талууд” гэж харилцаа холбооны нийтийн болон өртөг нэмэгдүүлэх үйлчилгээ эрхлэх зорилгоор цахилгаан холбооны аливаа сүлжээнд холбогдож буй этгээд болон бусдыг өөрийн сүлжээнд холбож буй сүлжээ эзэмшигчийг эсвэл сүлжээ хоорондын харилцан холболт хийж буй сүлжээ эзэмшигч талуудыг ойлгоно.

1.5.2. “Зохицуулах хороо” гэж Монгол Улсын Харилцаа холбооны зохицуулах хороог ойлгоно.

1.5.3. “Тусгай зөвшөөрөл” гэж харилцаа холбооны нийтийн үйлчилгээг тогтоосон хугацаа, нөхцөл, шаардлагын дагуу эрхлэн явуулах иргэн, хуулийн этгээдэд Зохицуулах хорооноос олгосон эрхийг ойлгоно.

1.5.4. “Зөвшөөрөл” гэж харилцаа холбооны нийтийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийн ангилалд бүртгүүлэхээр заасан үйлчилгээг эрхлэн явуулах иргэн, хуулийн этгээдэд Зохицуулах хорооноос олгосон бүртгэлийн гэрчилгээ болон тусгай зөвшөөрлийг аль алиныг нь ойлгоно.

1.5.5. “Тусгай зөвшөөрөл эзэмшигч” гэж харилцаа холбооны нийтийн үйлчилгээг тогтоосон хугацаа, нөхцөл, шаардлагын дагуу эрхлэн явуулахаар тусгай зөвшөөрөл авсан иргэн, хуулийн этгээдийг ойлгоно.

1.5.6. “Сүлжээ эзэмшигч” гэж харилцаа холбооны нийтийн үйлчилгээ эрхлэх зорилгоор цахилгаан холбооны болон мэдээллийн сүлжээ байгуулан үйлчилгээ эрхлэгчид буюу “А” ангиллын тусгай зөвшөөрөл эзэмшигчдийг ойлгоно.

1.5.7. “Техникийн нөхцөл” гэж аливаа сүлжээнд холбогдох техникийн стандарт, үзүүлэлтүүд, боломжийг ойлгоно.

1.5.8. “Нээлттэй сүлжээний стандарт” гэж тухайн сүлжээ нь техник, технологийн хувьд бусад харилцаа холбооны сүлжээтэй харилцан холбогдох боломжтой байхыг ойлгоно.

1.5.9. “Харилцан холболтын үйлчилгээ” гэдгийг энэхүү журмын 1.3.1-д заасан харилцан холболтыг ашиглан явуулж буй үйлчилгээний төрлүүд гэж ойлгоно

1.5.10. “Сүлжээнд холбогдох үйлчилгээ” гэдгийг ерөнхий журмын 1.3.2-т заасан холболтыг ашиглан явуулж буй үйлчилгээний төрлүүд гэж ойлгоно.

1.5.11. “Харилцан холболтын үйлчилгээний төлбөр” гэдгийг харилцан холболтын үйлчилгээг хэрэглэсэн хэрэглэгчийн төлж буй нэгж үйлчилгээний үнэ гэж ойлгоно.

1.5.12. “Харилцан холболтын үйлчилгээний орлого хуваарилах зарчим” гэдгийг харилцан холболтын үйлчилгээний төлбөрийг харилцан холболтонд оролцогч талууд өөрсдийн оролцооны хирээр хуваан авахаар тохиролцсон хувь хэмжээ эсвэл мөнгөн илэрхийлэл гэж ойлгоно.

1.5.13. “Сүлжээнд холбогдох үйлчилгээний төлбөр” гэдэг нь холболтонд оролцогч харилцаа холбооны нийтийн үйлчилгээ эрхлэгчид буюу “Б” ангиллын тусгай зөвшөөрөл эзэмшигчдээс тухайн холболтонд оролцогч сүлжээ эзэмшигчдэд төлж буй нэгж үйлчилгээний үнэ, “Б” ангиллын тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн үйлчилгээг хэрэглэсэн хэрэглэгчийн тухайн холболтонд оролцогч сүлжээ эзэмшигчид төлж буй нэгж үйлчилгээний үнэ гэж тус тус ойлгоно.

1.6. Энэ журмын дагалдах хавсралт журам, тэдгээрт болон энэ журманд оруулсан нэмэлт, өөрчлөлтүүд нь энэхүү журмын нэгэн адил хүчинтэй болно.

Хоёр. ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ

2.1. Зохицуулах хорооноос зөвшөөрөл авсан харилцаа холбооны үйлчилгээ эрхлэгч нь цахилгаан холбооны сүлжээнд холбогдох болон бусад сүлжээтэй харилцан холболт хийх эрхтэй байна.

2.2. Цахилгаан холбооны сүлжээнд холбогдох, харилцан холболт хийхдээ талууд ямар нэгэн ялгаваргүй буюу ижил нөхцлөөр хандах, ил тод, харилцан ашигтай байх зарчмыг баримтлана.

2.3. Талууд өрсөлдөөний эсрэг аливаа үйлдэл гаргахгүйгээр шударга өрсөлдөх зарчмыг баримтлана.

2.4. Цахилгаан холбооны сүлжээнд холбогдох, харилцан холболт хийхдээ талууд нээлттэй сүлжээний стандартыг хангах зарчмыг баримтлана.

2.5. Сүлжээ эзэмшигч нь өөрийн сүлжээнд холбогдох, харилцан холболт хийх нөхцөл, шаардлага, төлбөр, гэрээ хийх процедурын талаархи мэдээллийг нээлттэй байлгаж, хэвлэн нийтэлнэ.

2.6. Аливаа холболт, болон харилцан холболтын үнэ тарифыг тогтоохдоо өртөгт тулгуурласан, аль алиныхаа эрх ашигт нийцсэн, хүлээж авч болохуйц байлгана. Түүнчлэн бизнесийн аливаа алдагдлыг нөхөх зорилго тавихгүй болно.

2.7. Хэрэв урьд өмнө нь Монгол Улсад ашиглагдаагүй шинэ техник, технологийг нэвтрүүлэх зорилгоор сүлжээнд холбогдох, бусад сүлжээтэй харилцан холболт хийх үедээ техникийн нөхцлийг хангахад ямар нэгэн өөрчлөлт, нэмэлт хийх шаардлагатай болбол түүнтэй холбогдон гарах зардлыг хүсэлт гаргасан этгээд хариуцана.

2.8. Харилцан холбогдогч талууд нь харилцан холболтын төлбөр тооцоог гаргах нэгдсэн системтэй, тоолуур нь олон улсын стандартыг хангасан талаархи үйлдвэрлэгчийн баталгаатай байх шаардлагыг хангана.

2.9. Сүлжээ хоорондын орох болон гарах чиглэлд ачааллын таталцал, холбох ба хэрэглэгчийн шугамын ачааллын талаархи бүх төрлийн судалгааг хийх боломжийг хангана.

Гурав. МЭДЭЭЛЭЛ СОЛИЛЦОХ

3.1. Сүлжээ эзэмшигч болон тэдгээрийн сүлжээнд холбогдогч талууд нь өөрийн сүлжээнд холбогдох техникийн нөхцөл, холболтын төлбөр, сүлжээнд холбогдох гэж буй зорилго, сүлжээнд холбогдон үзүүлэх гэж буй үйлчилгээний талаархи танилцуулга зэрэг бизнесийн нууц бус мэдээллийг хүссэн талдаа гаргаж өгөх үүрэгтэй. Энэхүү мэдээллийг албан ёсоор хүсэлт гаргаснаас хойш ажлын 10 өдрийн дотор гаргаж өгнө.

3.2. Сүлжээнд холбогдох болон харилцан холболтын талаархи шаардлагатай мэдээллийг сүлжээ эзэмшигч нь нууц гэж үзвэл зөвхөн Зохицуулах хороонд гаргаж өгөх ба Зохицуулах хороо нууцлалыг хадгалах үүрэгтэй.

3.3. Талуудыг хоорондоо солилцох болон Зохицуулах хороонд гаргаж өгөх шаардлагатай мэдээллийг нуун дарагдуулах, хуурамч мэдээлэл гаргаж өгөх, гаргаж өгөхгүй удаах зэрэг үйлдэл гаргахыг хориглоно.

3.4. Талууд бусдаас авсан мэдээллийг өрсөлдөөний эсрэг ашиглахыг хориглоно.

Дөрөв. СҮЛЖЭЭНД ХОЛБОГДОХ БОЛОН ХАРИЛЦАН ХОЛБОЛТЫН ЗАХИАЛГА ГАРГАХ, ХҮЛЭЭН АВАХ БОЛОН ХАРИУГ ӨГӨХ ТУХАЙ

4.1. Аль нэг тал нөгөө талдаа цахилгаан холбооны сүлжээнд холбогдох болон харилцан холболт хийх хүсэлтийг бичгээр гаргана.

4.2. Захиалгыг хүлээн авсан тал уг хүсэлт нь өөрийн сүлжээний техникийн нөхцөл, шаардлагыг хангаж буй эсэх, өөрийн сүлжээнд холбох боломжтой эсэх талаар судлаж, ажлын 10 хоногийн дотор хариуг бичгээр өгөх бөгөөд хувийг Зохицуулах хороонд ирүүлнэ.

4.3. Сүлжээ эзэмшигч нь өөрийн сүлжээнд бусдыг холбогдох боломжийг аль болох бүрдүүлж өгнө. Тухайн үед техникийн нөхцөл гаргах боломжгүй байсан тохиолдолд хэдийд уг нөхцлийг бүрдүүлэх боломжтой тухайгаа хариуг өгөхдөө мэдэгдэнэ,

Тав. ТЕХНИКИЙН НӨХЦӨЛ ТОДОРХОЙЛОХ ТУХАЙ

5.1. Сүлжээг шинээр байгуулах, өргөтгөх, цахилгаан холбооны сүлжээнд холбогдон харилцаа холбооны нийтийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл хүсэгчдэд Зохицуулах хорооноос тусгай зөвшөөрөл эсвэл бүртгэлийн гэрчилгээ олгохдоо бусад сүлжээнд холбогдох техникийн нөхцөл, боломжтойг тодорхойлсон бусад сүлжээ эзэмшигчдийн тодорхойлолтыг харгалзан үзнэ.

5.2. Цахилгаан холбооны сүлжээнд холбогдох, сүлжээг шинээр байгуулах, өргөтгөх, бусад сүлжээтэй харилцан холболт хийх этгээд нь тусгай зөвшөөрөл авснаас хойш ажлын 30 хоногийн дотор бусад сүлжээ эзэмшигчдээс тэдгээрийн сүлжээнд холбогдох, харилцан холболт хийх техникийн нөхцлийг нарийвчлан тодруулж, техник, тоног төхөөрөмжийг хэдийд суурилуулж, холболтыг хийх, туршилтын хугацаа тогтоох эсэх, холболтын болон харилцан холболтын гэрээг хэдийд байгуулах талаар дахин хэлэлцэж, тохиролцоно.

5.3. Өртөг нэмэгдүүлэх үйлчилгээ эрхлэх зорилгоор цахилгаан холбооны сүлжээнд холбогдох этгээд нь сүлжээ эзэмшигчдээс техникийн нөхцлийг нарийвчлан авснаас хойш ажлын 90 хоногийн дотор холболтыг хийхгүй бол бусад сүлжээ эзэмшигчдээс өгсөн техникийн нөхцөл хүчингүй болно.

5.4. Харин харилцаа холбооны нийтийн үйлчилгээ эрхлэх зорилгоор сүлжээг шинээр байгуулах, бусад сүлжээтэй харилцан холболт хийх этгээд нь тусгай зөвшөөрөл авснаас хойш нэг жилийн хугацаанд үйлчилгээгээ эхлэхгүй, холболтыг хийхгүй бол Харилцаа холбооны тухай хуулийн дагуу түүнд олгосон тусгай зөвшөөрөл хүчингүй болох бөгөөд үүний хамт бусад сүлжээнд холбогдох техникийн нөхцөл нь мөн хүчингүй болно.

5.5. Сүлжээ эзэмшигч нь өөрийн сүлжээний техникийн нөхцөл шаардлага, холбох шугамын багтаамжийн ашиглалтын болон сүлжээнд нь холбогдох, харилцан холболт хийгдэхэд шаардагдах мэдээллийг Зохицуулах хороонд жил бүрийн 3 ба 7 -р сарын 30-ны дотор гаргаж өгнө. Өөрчлөлтийг тухай бүрд нь мэдэгдэж байна.

5.6. Сүлжээ байгуулан үйлчилгээ эрхлэж буй тусгай зөвшөөрөл эзэмшигч нь өөрийн сүлжээг өргөтгөх, шинэчлэх, татан буулгах зэрэг өөрчлөлтийн үед 3 сарын өмнө шаардлагатай техникийн нөхцлүүдийг бусад сүлжээ эзэмшигчдэд мэдэгдэн тохиролцож, энэ талаар Зохицуулах хороонд мэдэгдэнэ.

5.7. Зохицуулах хорооноос шаардлагатай үед холбогдох шалгалт, хэмжилтийг зохион байгуулж болно.

Зургаа. ХАРИЛЦАН ХОЛБОЛТЫН ҮЙЛЧИЛГЭЭ БОЛОН СҮЛЖЭЭНД ХОЛБОГДОХ ҮЙЛЧИЛГЭЭ

6.1 Харилцан холболтонд оролцогч талуудын сүлжээний төрлөөс үл шалтгаалан энэхүү журмаар зохицуулагдах харилцан холболтын үйлчилгээг дараах байдлаар ангилна:

- 6.1.1. Хотын дотор дуудлага хүлээн авах үйлчилгээ;
- 6.1.2. Хотын дотор дуудлага хийх үйлчилгээ;
- 6.1.3. Хот хоорондын дуудлага хүлээн авах үйлчилгээ;
- 6.1.4. Хот хоорондын дуудлага хийх үйлчилгээ;
- 6.1.5. Хотын дотор дуудлага дамжуулах үйлчилгээ;
- 6.1.6. Хот хооронд дуудлага дамжуулах үйлчилгээ;
- 6.1.7. Улс хоорондын дуудлага хүлээн авах үйлчилгээ;
- 6.1.8. Улс хоорондын дуудлага хийх үйлчилгээ;
- 6.1.9. Улс хоорондын гарах дуудлага дамжуулах үйлчилгээ;
- 6.1.10. Улс хоорондын орох дуудлага дамжуулах үйлчилгээ.

6.2. Цахилгаан холбооны сүлжээнд холбогдогч талуудын үйлчилгээний төрлөөс үл шалтгаалан сүлжээнд холбогдох үйлчилгээг дараах байдлаар ангилна:

- 6.2.1. Интернет ашиглан улс хооронд дуудлага хийх үйлчилгээ;
- 6.2.2. Интернет ашиглан улс хооронд дуудлага хүлээн авах үйлчилгээ;
- 6.2.3. Хотын дотор интернетийн Dial-up холболт хийх үйлчилгээ;
- 6.2.4. Хот хооронд интернетийн Dial-up холболт хийх үйлчилгээ;
- 6.2.5. Бусад.

Долоо. ЗААГЛАХ ЦЭГ ТОДОРХОЙЛОХ ТУХАЙ

7.1. Цахилгаан холбооны сүлжээнд холбогдох болон сүлжээ хоорондын харилцан холболтын зааглах цэгийг Харилцаа холбооны тухай хуулийн дагуу энэхүү журмыг баримтлан тогтооно.

7.2. Энэхүү журмын 5.2 дахь заалтанд зааснаар сүлжээнд холбогдох, харилцан холболт хийх техникийн нөхцлийг дахин авч, техник, тоног төхөөрөмжийг хэдийд суурилуулж, холболтыг хийх талаар талууд тохиролцох үедээ зааглах цэгийг тодорхойлно.

7.3. Сүлжээ хоорондын зааглах цэгийг ажлын 15 хоногийн дотор тогтооно.

7.4. Сүлжээ эзэмшигч нь харилцан холболт хийхээр хүсэлт гаргасан бусад сүлжээ эзэмшигчийг өөрийн сүлжээний холбох шугам хуваарилах зогсуурт (DDF) холбох боломжоор хангана.

7.4.1. Харилцан холболт хийхээр хүсэлт гаргасан сүлжээ эзэмшигч нь (цаашид холбогдогч тал гэнэ) холбох шугамаа тухайн сүлжээ хүртэл байгуулсан бол зааглах цэг нь тухайн сүлжээний холбох шугам хуваарилах зогсуурт байна. (хавсралт зураг 1.) Тухайн сүлжээний холбох шугам хуваарилах зогсуур нь өөрийн эзэмшлийн эсвэл бусдын эзэмшлийн (co-location) аль ч байранд байж болно.

7.4.2. Сүлжээ хоорондын холбох кабель шугамыг эсвэл сувгийг холбогдогч тал тухайн сүлжээ эзэмшигчээс түрээслэх бол зааглах цэг нь мөн сүлжээ эзэмшигчийн холбох шугам хуваарилах зогсуурт байна. (Хавсралт зураг 2.)

7.5. Сүлжээ эзэмшигч нь өөрийн сүлжээний хэсгийг (техник төхөөрөмж, холбох шугам, суваг, хэрэглэгчийн шугам) түрээслэж байгаа тохиолдолд зааглах цэг нь сүлжээний дараах хэсгүүд дээр байж болно. Үүнд:

- Кросс буюу хэрэглэгчийн шугам хуваарилах зогсуур (MDF)
- Холбох шугам хуваарилах зогсуур (DDF)
- Хуваарилах шүүгээ
- Хуваарилах хайрцаг

7.6. Хэрэглэгчийн шугам ашиглан сүлжээнд холбогдох үед зааглах цэгийн байршлыг дараах байдлаар тогтооно.

7.6.1. Хэрэглэгч нь байшин барилга, орон сууцанд байрлаж байгаа бол зааглах цэг нь барилгын доторх уг хэрэглэгчийн холбогдсон хуваарилах хайрцагт байна.

7.6.2. Хэрэглэгч нь гэр хороололд байрлаж байгаа бол зааглах цэг нь агаарын шугамын эцсийн багана дээрхи хуваарилах хайрцагт байна.

7.6.3. Хэрвээ хэрэглэгч өөрөө кабель шугамаа байгуулсан бол уг хэрэглэгчээс түүний татсан кабель шугам дуусах цэгийг зааглах цэг гэж үзнэ. Энэ нь кабель шугамын төгсгөлийн худаг шүүгээ, хайрцаг, кросс (MDF) байж болно.

7.7. Сүлжээнд холбогдохоор эсвэл харилцан холболт хийхээр хүсэлт гаргасан тал нь 6.4, 6.5, 6.6 -д дурдсан хэсгүүдээс өөр газарт зааглах цэг тогтоохоор хүсэлт гаргавал сүлжээ эзэмшигч хүсэлтийн дагуу техникийн боломж байгаа эсэхийг тодорхойлж, Зохицуулах хороонд ирүүлнэ. Уг тодорхойлолт нь цаашид тухайн цэгийг зааглах цэг гэж үзэх эсэх үндэслэл болно. Техникийн боломжгүй бол сүлжээ эзэмшигч тодорхойлолтодоо өөр боломжуудыг санал болгоно.

7.7.1. Зохицуулах хороо тодорхойлолтыг хүлээн авснаас хойш ажлын 5 хоногт багтаан хариу өгнө.

7.8. Зааглах цэгээс шугамыг хоёр тийш нь таслан шалгалт, хэмжилт хийх техникийн боломж, нөхцлийг хангасан байна.

Найм. ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЧАНАР

8.1. Сүлжээ эзэмшигч нь өөрийн сүлжээнд бусдыг холбох болон бусад сүлжээтэй харилцан холбогдохдоо өөрийн сүлжээнд үзүүлж буй чанарын ижил түвшинг хангана.

8.2. Сүлжээний чанарын үзүүлэлтүүдийг тогтоох, тэдгээрийг үнэлэхэд “Харилцаа холбооны үйлчилгээний чанарыг хянах журам”-ыг баримтлана.

Ес. АШИГЛАЛТ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТУХАЙ

9.1. Энэхүү журмын 6.4.2, 6.5 -д зааснаас (түрээсийн шугам ашиглахаас) бусад тохиолдолд зааглах цэгээс 2 тийш талууд өөрсдийн шугам, төхөөрөмжийн ашиглалт үйлчилгээ, гэмтэл засварыг хариуцна.

9.1.1. Энэхүү журмын 6.4.2, 6.5 -д заасан тохиолдлуудад “Харилцаа холбооны сүлжээ, инженерийн барилга байгууламжийг хэсэгчлэн түрээслүүлэх журам”-ын 7.3-т заасны дагуу түрээслүүлж буй сүлжээний хэсгийн ашиглалт үйлчилгээг сүлжээ эзэмшигч өөрөө хариуцна.

9.2. Сүлжээнд холбогдох, сүлжээг хуваан ашиглах болон сүлжээ хоорондын харилцан холболтын аливаа туршилт, урьдчилан сэргийлэх хэмжилт, шалгалтын үед ажиллах горим, хугацааг талууд урьдчилан харилцан тохиролцон тогтоож, мөрдөн ажиллана.

9.3. Сүлжээнд холбогдох болон сүлжээ хоорондын харилцан холболтын үед гарсан бусдын үйлчилгээнд нөлөөлж болохуйц, эсвэл үйлчилгээг тасалдуулж болзошгүй гэмтэл саатлын талаар урьдчилан тохиролцсон хугацаанд мэдэгдэх, шуурхай арга хэмжээ авч, түргэн засварлах, тэдгээртэй холбоотой зардлыг гэмтэл гаргасан тал нь хариуцах зэрэг ашиглалтын үед гарч болох гэмтэл сааталтай холбоотой асуудлуудыг холболтын болон харилцан холболтын гэрээнд тодорхой тусгаж, мөрдөн ажиллана.

Арав. ХАРИЛЦАН ХОЛБОЛТЫН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ БОЛОН СҮЛЖЭЭНД ХОЛБОГДОХ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТӨЛБӨР ТОГТООХ, ТӨЛБӨРИЙГ ГЭРЭЭНД ТУСГАХ

10.1. Харилцан холболтын болон сүлжээнд холбогдох гэрээнд тусгагдах харилцан холболтын болон сүлжээнд холбогдох үйлчилгээний төлбөр, харилцан холболтын үйлчилгээний орлого хуваарилах зарчмыг дараах байдлаар тогтооно. Үүнд:

10.1.1. Гэрээнд оролцогч талууд харилцан холболтын болон сүлжээнд холбогдох гэрээнд тусгах харилцан холболтын үйлчилгээний болон сүлжээнд холбогдох үйлчилгээний төлбөрийн, орлого хуваарилах зарчмын тухай харилцан тохиролцсон эцсийн саналыг, тохиролцоонд хүрээгүй бол тус тусын саналыг үндэслэлийн хамт гэрээ байгуулахаас ажлын 21 хоногийн өмнө Зохицуулах хороонд ирүүлнэ.

10.1.2. Зохицуулах хороо нь энэхүү журмын 10.1.1 заалтын дагуу гэрээнд оролцогч талуудын ирүүлсэн саналыг тооцооны үндэслэл болон тухайн салбарт төрөөс баримтлах бодлого, чиглэл, шударга өрсөлдөөний нөхцөлийг бүрдүүлэх, хэрэглэгчдийн эрх ашгийг хамгаалах зорилгын хүрээнд хянан, шийдвэрлэнэ.

10.1.3. Зохицуулах хороо нь гэрээнд оролцогч талуудын ирүүлсэн саналыг хянаад үндэслэлтэй гэж үзвэл ирүүлсэн саналыг зөвшөөрсөн тухай шийдвэрийг, хэрэв үндэслэлгүй гэж үзвэл ирүүлсэн саналаа дахин хянан үзэх тухай мэдэгдлийг, дүгнэлтийн хамт талуудад хүргүүлнэ.

10.1.4. Гэрээнд оролцогч талууд хорооноос хүргүүлсэн мэдэгдэл, дүгнэлтийг хүлээн авснаас хойш 14 хоногийн дотор шинэчилсэн саналаа үндэслэлийн хамт ирүүлээгүй эсвэл ирүүлсэн санал нь 10.1.2-т заасан хүрээнд хянан үзэхэд хүлээн авах боломжгүй тохиолдолд зохицуулах хороо нь гэрээнд тусгах харилцан холболтын үйлчилгээний болон сүлжээнд холбогдох үйлчилгээний төлбөр, харилцан холболтын үйлчилгээний орлого хуваарилах зарчмыг тогтоон, шийдвэрийг талуудад хүргүүлнэ.

10.1.5. Гэрээнд оролцогч талууд тухайн сүлжээний төрөл болон онцлогоос үл шалтгаалан гэрээнд тусган мөрдөх харилцан холболтын болон сүлжээнд холбогдох үйлчилгээний төлбөр, харилцан холболтын үйлчилгээний орлого хуваарилах зарчмыг зохицуулах хорооны шийдвэрийн дагуу гэрээнд тусган, гэрээг байгуулна.

10.1.6. Зохицуулах хорооноос гэрээ байгуулагдахаас өмнө болон гэрээний үргэлжлэх хугацааны дундуур харилцан холболтын болон сүлжээнд холбогдох үйлчилгээний төлбөр, орлого хуваарилах зарчмын талаар шийдвэр гаргасан тохиолдолд гэрээнд оролцогч талууд шийдвэрийг гэрээнд шууд тусган дагаж мөрдөнө.

10.2. Энэхүү журмын зургаадугаар бүлэгт тусгагдаагүй харилцан холболтын үйлчилгээний болон сүлжээнд холбогдох үйлчилгээний төлбөр, харилцан холболтын үйлчилгээний орлого хуваарилах зарчмыг гэрээнд тусгах бол талууд харилцаа холбооны үйлчилгээний тариф тогтоох аргачлалыг мөрдөж ажиллана.

Арван нэг. ХОЛБОЛТЫН БОЛОН ХАРИЛЦАН ХОЛБОЛТЫН ГЭРЭЭ БАЙГУУЛАХ

11.1. Холболтын болон харилцан холболтын гэрээг байгуулж, талууд гарын үсэг зурсан өдрөөс хойш ажлын 10 хоногийн дотор уг гэрээг хавсралт, холбогдох баримт бичгийн хамт Зохицуулах хороонд бүртгүүлэхээр ирүүлнэ. Мөн гэрээнд орсон нэмэлт өөрчлөлт бүрийг тухай бүр Зохицуулах хороонд бүртгүүлэхээр хүргүүлнэ.

11.2. Зохицуулах хороо нь энэхүү журмын дагуу байгуулагдаагүй гэрээг бүртгэхээс татгалзах эрхтэй. Хэрэв талуудын ирүүлсэн гэрээг Зохицуулах хороо бүртгэж авахаас татгалзсан бол талууд уг гэрээг журамд нийцүүлэн дахин шинэчлэн байгуулна.

11.3. Талууд гэрээг байгуулахаас өмнө Зохицуулах хороонд хандаж, гэрээний төслийг хянуулах болон холбогдох заавар зөвлөмжийг авч болно.

11.4. Холболтын болон харилцан холболтын гэрээнд дараах зүйлүүдийг заавал тусгана. Үүнд:

11.4.1. Гэрээний ерөнхий зүйлд хамаарах заалтууд:

11.4.1.1. Гэрээг байгуулах хууль, эрх зүйн үндэслэл;

11.4.1.2 . Гэрээг байгуулж буй талуудын нэр, хаяг, төлөөлж буй албан тушаалтан;

11.4.1.3. Холболтын болон харилцан холболтын зорилго, төрөл, хамрах хүрээ;

11.4.1.4. Туршилтаар ажиллуулахаар тохиролцсон бол туршилтын хугацаа;

11.4.1.5. Талуудын эрх үүрэг;

11.4.1.6. Гэрээг сунгах, өөрчлөх, цуцлах үндэслэл.

11.4.2 Техникийн нөхцөл шаардлагын талаар:

11.4.2.1. Ашиглах техник, технологийн тухай, техникийн үзүүлэлтүүд;

11.4.2.2. Хэрэглэгчийн нийт багтаамж;

11.4.2.3. Сүлжээний холбох шугамын багтаамж;

11.4.2.4. Интерфэйсийн үзүүлэлтүүд;

11.4.2.5. Сүлжээний дохиолол, синхрончлол;

11.4.2.6. Цаашид өргөтгөх, өөрчлөлт оруулахаар төлөвлөж буй эсэх;

11.4.2.7. Сүлжээний зааглах цэг, түүний байршил;

11.4.2.8. Холболтын болон сүлжээ хоорондын харилцан холболтын зураглал;

11.4.2.9. Сүлжээний ачааллын хэмжээ;

11.4.2.10. Гэмтэл саатлыг хянах боломж;

11.4.2.11 Дугаарлалт.

11.4.3. Ашиглалт, үйлчилгээний талаар:

11.4.3.1. Ашиглалт үйлчилгээг хэвийн байлгах талаар харилцан мэдээлэл солилцох албан тушаалтан, хаяг, холбоо барих хэрэгсэл;

11.4.3.2. Өгөгдөл, чиглэл үүсгэх, өөрчлөлт оруулах, тодотгол, тулгалт хийх, хаах талаар;

11.4.3.3. Ачаалал хэмжилт, судалгааг хийх талаар;

11.4.3.4. Нэмэлт үйлчилгээний нэр төрөл;

11.4.3.5. Тойруу холбоо зохион байгуулах эсэх талаар;

11.4.3.6. Өөр, өөрийн сүлжээнээс болон хэрэглэгчдээс учруулж болох нөлөөллөөс анхааруулах, гэмтлээс урьдчилан сэргийлэх талаар;

11.4.3.7. Гэмтэл саатлын үед ажиллах горим /мэдэгдэх, засварлах хугацаа, бүртгэл/;

11.4.3.8. Урьдчилан сэргийлэх үзлэг шалгалт хийх хуваарь, хугацаа;

11.4.3.9. Ашиглалтын үед талуудын харилцан хүлээх үүрэг, хариуцлага;

11.4.3.10. Сүлжээ хоорондын харилцан холболтыг дараах нөхлүүдээс бусад ямар ч тохиолдолд салгах болон хязгаарлалт хийхийг хориглоно. Үүнд:

А. Давагдашгүй хүчин зүйлс;

Б. Гэрээнд оролцогч тал цаашид үйл ажиллагаа явуулах боломжгүй болсон болон дампуурсанаа албан ёсоор зарласан;

В. Гэрээнд оролцогч тал харилцан холболтын төлбөрөө төлөөгүй гэрээнд тохиролцсон боломжит хугацаанаас 3 сараар хэтрүүлсэн;

Г. Гэрээгээр тохиролцсон техникийн гэмтэл саатал, засвар;

(Энэ заалтад 2009 оны 8 дугаар сарын 28-ны өдрийн 34 дүгээр тогтоолоор нэмэлт оруулсан.)

11.4.3.11. Дээрх нөхцлүүдийн дагуу цахилгаан холбооны сүлжээ хоорондын харилцан холболтыг салгах, хязгаарлалт хийхдээ Зохицуулах хороонд 72 цагийн өмнө, өөрийн сүлжээний болон гэрээнд оролцогч талын хэрэглэгчдэд 42 цагийн өмнө, урьдчилан мэдэгдэх тухай талууд үүрэг хүлээх.

(Энэ заалтад 2009 оны 8 дугаар сарын 28-ны өдрийн 34 дүгээр тогтоолоор нэмэлт оруулсан.)

11.4.4. Төлбөр тооцооны талаар:

11.4.4.1. Зохицуулах хороо өөрөөр тогтоогоогүй бол харилцан холбогдогч талуудад ноогдож буй төлбөрийн хэсэг бүр нь сүлжээний төрөл ба онцлогоос үл шалтгаалан ямагт өртгөө нөхсөн байна.

11.4.4.2. Харилцан холболтын үйлчилгээний өртгийг тооцоолохдоо ОУЦХБ аас гаргасан зөвлөмж, аргачлал загвар, нягтлан бодох бүртгэлийн хуулийн хүрээнд хөтөлсөн зардлын бүртгэлийг үндэслэл болгосон байх

11.4.4.3. Үйлчилгээ бүрийн нэгж хэмжээг нарийвчлан тусгах

11.4.4.4. Төлбөр тооцоо хийх чиглэл, хамрах хүрээ, хугацааны хуваарь

11.4.4.5. Тоолуур нь гарах ба орох горимд зөв ажиллаж байгаа эсэх талаар туршилт

хийж, баталгаажуулан протокол гаргуулсан байх

11.4.4.6. Хэрхэн яаж зохион байгуулах, хариуцах албан тушаалтан

11.4.4.7. Солилцох хэлбэр/ цаасаар, дискээр, электрон хэлбэрээр гэх мэт/

11.4.4.8. Төлбөр хийх алхам, өгөгдлүүд, формат

11.4.4.9. Нэгж үйлчилгээ бүрийн төлбөр, орлого хуваарилах зарчим

11.4.4.10. Төлбөр тооцоо хийх нөхцөл, арга хэрэгсэл / хөнгөлөлт үзүүлэх, кредитээр хийх, балансжуулах, хугацаа хожимдуулсны алданги тооцох гэх мэт/

11.4.4.11 Нэмэгдсэн өртгийн албан татварыг хэрхэн тайлагнах, тооцоо хийх үүрэг

хариуцлага

11.4.5. Харилцан мэдээлэл солилцох талаар:

11.4.5.1. Өөр хоорондоо солилцох мэдээллийн төрөл;

11.4.5.2. Мэдээллийг солилцох албан тушаалтан;

11.4.5.3. Мэдээлэл солилцох хэлбэр, арга;

11.4.5.4. Мэдээллийн нууцлал, үнэн зөв байх талаар батламж гаргах тухай.

11.4.6 Хариуцлага

11.4.6.1. Гэрээг зөрчсөн тохиолдолд хүлээх хариуцлага;

11.4.6.2. Аль нэг талын буруугаар үйлчилгээ саатахад хүлээх хариуцлага;

11.4.6.5. Гарсан маргааныг шийдвэрлэх арга замууд;

11.4.6.6. Гэрээг дахин авч үзэх, дахин тохиролцоход авах арга хэмжээ;

11.4.6.7. Гэрээнд гарын үсэг зурахаар итгэмжлэгдсэн албан тушаалтны нэр, гарын үсэг;

11.4.6.8. Гэрээг байгуулсан болон хүчин төгөлдөр болох хугацаа.

11.5. Холболт болон харилцан холболттой холбогдон сүлжээний хэсэгчилэн түрээс, дэд бүтцийг хувааж ашиглах, түүнчлэн өөрийн барилга байгууламжийн байршлийг ашиглуулах зэрэг асуудлууд гарах тохиолдолд энэ журмын дагалдах хавсралт журмын дагуу тухайн төрөлд нийцэх гэрээг холболтын болон харилцан холболтын гэрээний хавсралт болгон үйлчилгээ тус бүрээр хийнэ.

11.6. Зохицуулах хороо холболтын болон харилцан холболтын гэрээний хэрэгжилтийг бүртгэлээр хянах, илэрсэн зөрчлийг арилгах талаар үүрэг даалгавар өгөх, маргаантай асуудлыг шийдвэрлэх зэрэг арга хэмжээг авч ажиллана.

Арван хоёр. МАРГААН ШИЙДВЭРЛЭХ ТАЛААР

12.1. Сүлжээнд холбогдох болон сүлжээ хоорондын харилцан холболтын нөхцөл, зааглах цэг, төлбөр, энэхүү журам болон гэрээг зөрчсөн, өрсөлдөөний эсрэг үйлдэл гаргасан зэрэг маргаантай асуудлыг маргалдагч талууд шат шатандаа шийдвэрлэхийг оролдох бөгөөд шийдвэрлэж чадахгүй тохиолдолд Харилцаа холбооны тухай хуулийн дагуу Зохицуулах хороо бүрэн эрхийнхээ хүрээнд шийдвэрлэнэ.

12.2. Маргааныг шийдвэрлэхдээ Зохицуулах хорооноос баталсан “Гомдол, маргаан шийдвэрлэх журам” болон энэхүү журмыг мөрдлөгө болгоно.

12.3. Энэхүү журмын 9.2 дахь заалтын дагуу бүртгүүлээгүй гэрээтэй холбоотой үүссэн маргааныг Зохицуулах хороо шийдвэрлэхгүй болно.

12.4. Маргаантай асуудлыг шийдвэрлэхдээ Зохицуулах хороо дараах аргуудыг хэрэглэж болно. Үүнд:

12.4.1. Маргаантай асуудлыг судлахын тулд шаардлагатай мэдээллийг талуудаас авах;

12.4.2. Авсан мэдээллийг судлах, дүн шинжилгээ хийх, баримт гаргаж тавих;

12.4.3. Талуудын тайлбар, саналыг сонсох, шаардлагатай гэж үзвэл олон нийтийн санал авах;

12.4.4. Шаардлагатай бол хэмжилт, шалгалтыг хийх, факт гаргаж тавих;

12.4.5. Ижил төстэй байгууллагууд болон гадаадын туршлагыг судлан харьцуулалт хийх;

12.4.6. Маргаантай асуудлыг өөрсдийн мэргэжилтнүүдээр судлуулан санал дүгнэлтийг нь үндэслэх;

12.4.7. Тухайн чиглэлээр мэргэшсэн мэргэжилтнүүд, хуульчид, эдийн засагчид, эрдэмтэд зэргээс бүрдсэн тусгай ажлын хэсэг гарган ажиллуулах;

12.4.8. Маргалдагч талуудын төлөөлөгчдөөс бүрдсэн ажлын бус зөвлөлийг Зохицуулах хороо санаачлан байгуулж, тухайн асуудлаар санал солилцуулан нэгдсэн шийдвэрт хүргэхэд чиглэсэн ажлыг зохион байгуулах.

12.5. Зохицуулах хороо нь маргаантай асуудлаар мэргэжлийн дүгнэлт гаргах, санал зөвлөмж өгөх, гэрээг дахин авч үзэх тухай хугацаатай үүрэг даалгавар өгөх, маргааныг шийдвэрлэж болох хувилбаруудыг санал болгох зэргээр тодорхой шийдвэрийг гаргана.

12.6. Зохицуулах хороо нь маргаантай асуудлаар гаргах шийдвэрийнхээ тухай урьдчилан талуудад танилцуулж саналыг нь авах, нээлттэй хуралдаанаар хэлэлцэж шийдвэрлэх зэргээр ил тод зарчмыг баримтлана.

12.7. Зохицуулах хороо нь маргаантай асуудлаар тухайн нөхцөл байдалд тохируулан үл ялгаварлахгүй, хүнд сурталгүйгээр, шударга, өрсөлдөөнийг дэмжсэн шийдвэр гаргана.

12.8. Зохицуулах хорооноос гаргасан шийдвэрийг маргалдагч талууд аль болох хүлээж авна. Хэрэв Зохицуулах хорооны шийдвэрийг хүлээн зөвшөөрөхгүй бол шүүхэд хандаж болно.

12.9. Зохицуулах хороо нь энэхүү журмын 11.4.3.10-д зааснаас бусад нөхцлөөр сүлжээ хоорондын салгалт, хязгаарлалт хийсэн этгээдэд 13.4-д заасан арга хэмжээг авна.

(Энэ заалтад 2009 оны 8 дугаар сарын 28-ны өдрийн 34 дүгээр тогтоолоор нэмэлт оруулсан.)

Арван гурав. ХАРИУЦЛАГА

13.1. Энэхүү журмыг зөрчсөн тохиолдолд Зохицуулах хороо нь холбогдох хууль тогтоомжийн дагуу шаардлагатай арга хэмжээг авна. Үүнд:

13.1.1. Зөрчлийг арилгуулах тухай хугацаатай үүрэг даалгавар, шаардлага өгөх;

13.1.2. Захиргааны хариуцлага хүлээлгэх арга хэмжээ авахуулахаар холбогдох хяналтын байгууллагад мэдэгдэх

13.1.3. Тусгай зөвшөөрлийг нь түдгэлзүүлэх, хүчингүй болгох тухай сануулах

13.1.4. Тусгай зөвшөөрлийг нь түдгэлзүүлэх

13.1.5. Тусгай зөвшөөрлийг нь хүчингүй болгох

13.1.6. Гаргасан зөрчил, зөрчлийг арилгуулахаар авсан арга хэмжээний талаар нийтэд мэдээлэх

/Энэхүү журамд 2004 оны 19, 2006 оны 10, 2009 оны 34 дүгээр тогтоолоор орсон нэмэлт, өөрчлөлтийг тусгав./

----- о О о -----